



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/101

Чингис хот

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах Бор нэртэй MV-021413 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Өвөр голд” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг “Өвөр голд” ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Еаярхүү/, Бор-Өндөр сумын Засаг дарга /П.Чинбат/ нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах аюулгүйн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010295

Аймгийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 25 өдрийн 2/10/1
дугаар захирамжийн хавсралт

“Өвөр голд” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн
агуулахын газрын байнгын байршил

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	46	16	49.11	109	19	22.77
2	46	16	45.93	109	19	22.41
3	46	16	45.99	109	19	17.92
4	46	16	49.16	109	19	18.17